



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/191

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 78 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Тома-Алтай" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/-н 2 дугаар багц болох Суудлын автомашин /toyota say дүйцэхүйц/ худалдан авах нийлүүлэлтийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Мөнхцэцэг	- Эрүүл мэндийн газрын Санхүү удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд: А.Жамъяансүрэн	- Мэргэжлийн хяналтын газрын хэлтсийн дарга улсын ахлах байцаагч
Ш.Хабива	- Зоонозын өвчинтэй тэмцэх төвийн нягтлан бодогч
Д.Балт	- Авто тээврийн төвийн шинжээч
Ц.Цолмонбаатар	- Стандарт, хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
Ц.Даваасамбуу	- Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
С.Батдорж	- Аймгийн архивын тасгийн дарга
П.Болормаа	- "Тома-Алтай" ХХК-ийн захирал
Нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэбат	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. “Тома-Алтай” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Мөнхцэцэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ДЭЛГЭРСАЙХАН